*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 8 дугаар хавсралт*

# ЧАНАР ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГА И.ХАЙРАТБЕКИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр:Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар
Нэгжийн нэр: Чанар хяналтын газар

## 1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | Нийт (70 оноо) |
|---|---|---|---|
| **“АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД 2021-2030 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 5.3.11, ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГЫН 6.1.1, МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН 5.2.1, МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 4.3.1.1, 4.3.1.4** | | | |
| **Зорилт 1: “Төрийн цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх” зорилтын хүрээнд** | | | |
| 1. | Төрийн цахим үйлчилгээтэй холбоотой салбар дундын зохицуулалт хийх байгууллагатай уулзалт зохион байгуулах; | 100 | 70 |
| 2. | Төрийн цахим үйлчилгээг дахин загварчлах үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах; | 100 | 70 |
| **Зорилт 2: “Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлж, цахим шилжилтийг эрчимжүүлэх” зорилтын хүрээнд** | | | |
| 3. | Цахим шилжилтийг эрчимжүүлэх хүрээнд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд Нээлттэй мэдээллийн системийн талаар мэдээлэл хариуцагч байгууллагуудад зөвлөгөө, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулах; | 100 | 70 |
| 4. | Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-д шилэн индексийн тайлан илгээх, үнэлэх, баталгаажуулах, хэвлэн нийтлэх чиглэлээр контент бэлтгэх, мэдээлэл хариуцагч байгууллагуудад түгээх ажлыг зохион байгуулах; | 100 | 70 |
| 5. | Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр төрийн цахим үйлчилгээг үзүүлж байгаа албан хаагчдад төрийн цахим үйлчилгээний талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх; | 100 | 70 |
| 6. | Төрийн цахим үйлчилгээтэй холбоотой асуудлаар хүн, хуулийн этгээдтэй харилцах эргэх холбооны тогтолцоог бүрдүүлэх; | 100 | 70 |
| 7. | Хүн, хуулийн этгээдээс тусгай дугаараар болон бусад хэлбэрээр ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авах, холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэх, хяналт тавих. | 100 | 70 |
| **Зорилт 3: “Төрийн цахим үйлчилгээнд инновац, дэвшилтэт технологи (дижитал)-ийг нэвтрүүлж системийн интеграци хийх” зорилтын хүрээнд** | | | |
| 8. | Төрийн цахим үйлчилгээний процессын дахин инженерчлэлийг, зохион байгуулалтаар хангах; | 100 | 70 |
| 9. | Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-д мэдээлэл хариуцагч байгууллагын шилэн индексийн тайлан илгээх, хүлээн авах, үнэлэх, баталгаажуулах, хэвлэн нийтлэх байдалд хяналт тавих, хяналтын тогтолцоог сайжруулах ажлыг зохион байгуулах; | 100 | 70 |
| 10. | Төрийн цахим үйлчилгээний ХУРДАН цэгийн хэвийн үйл ажиллагаа, үйлчилгээний ажилтны үйлчилгээ | 100 | 70 |

| | | | |
|---|---|---|---|
| | үзүүлэхэд мөрдөгдөх хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт бусад шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, зөвлөмж хүргүүлэх; | | |
| 11. | Төрийн цахим үйлчилгээний ХУРДАН цэгийн хэвийн үйл ажиллагаанд хяналтын камераар хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээг холбогдох нэгжтэй хамтран зохион байгуулах; | 100 | 70 |
| 12. | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (киоск)-д нэвтрүүлсэн төрийн цахим үйлчилгээний хэвийн үйл ажиллагаанд хяналт тавих; | 100 | 70 |
| 13. | Газрын үйл ажиллагаа, хүн, хуулийн этгээдэд төрийн цахим үйлчилгээг операторын горимоор хүргэх “ХУРДАН” цэгт мэдээллийн аюулгүй байдлын аудитыг эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн хуулийн этгээдээр хийлгэх, зөвлөн туслах үйлчилгээ авах; | 100 | 70 |
| 14. | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-ийн хөгжүүлэлтийн явцад хяналт тавих, ХУРДАН цэгийн техник тоног төхөөрөмж, программ хангамж, сүлжээний хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдалд хяналт, шинжилгээ үнэлгээ хийж зөвлөмж хүргүүлэх. | 100 | 70 |
| **Зорилт 4: “байгууллагын үйл ажиллагааны үр дүн, бүтээмжийг дээшлүүлэх” зорилтын хүрээнд** | | | |
| 15. | Салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хууль, тогтоолын төсөлд санал өгөх; | 100 | 70 |
| 16. | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 100 дугаар тогтоолд нэмэлт өөрчлөлтийн оруулах санал боловсруулах, хүргүүлэх; | 100 | 70 |
| 17. | Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн баталж, биелэлтийг хангах; | 100 | 70 |
| 18. | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-д дэд админ, операторын админ, операторын эрх нээх, цуцлах, хяналт тавих; | 100 | 70 |
| 19. | Төрийн цахим үйлчилгээг өргөжүүлж, хүртээмжийг сайжруулснаар хэмнэгдэж болох ажлын байр, зардлын судалгаа боловсруулах; | 100 | 70 |
| 20. | Төрийн байгууллагаас болон хүн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа үйлчилгээний тоон үзүүлэлтийн талаарх судалгааг дахин боловсруулах. | 100 | 70 |

## 2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|---|
| 1. | Байгууллагаас болон бусад газраас зохион байгуулах сургалтад хамрагдана. | 100 | 15 |
| **Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо** | | | |

## 3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ

| Д/д | Үзүүлэлт | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (7 хүртэл оноогоор) |
|---|---|---|
| 1. | Хандлага, ёс зүй | 4,1 |
| 2. | Удирдан зохион байгуулах | 4,1 |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 4,1 |
| 4. | Манлайлах | 4,1 |

| | | |
|---|---|---|
| 5. | Багаар ажиллах | 4,1 |
| 6. | Харилцаа | 4,1 |
| **Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо** | | 4,1 |

### 4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Хамт олны үнэлгээ (8 хүртэл оноогоор) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | 4,1 |
| 2. | Багаар ажиллах | 4,1 |
| 3. | Харилцаа | 4,1 |
| **Дундаж оноо** | | 4,1 |

### 5. Гүйцэтгэлийн үнэлгээ

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт)* | 70 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт *(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ )* | 15 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ )* | 4,1 |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | 4,1 |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | |
| **Нийт оноо** = ( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо | | 93,2 |

***Үнэлгээ өгсөн:*** ***Төсвийн шууд захирагч***

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дарга .............................. /П.Батбаатар/
*2025.06.06*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Нэгжийн дарга:***

Чанар хяналтын газрын дарга .............................. /И.Хайратбек/
*2025.06.10*

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

# ЧАНАР ХЯНАЛТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл -ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | |
| **“АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД 2021-2030 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 5.3.11, ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГЫН 6.1.1, МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН 5.2.1, МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 4.3.1.1, 4.3.1.4** | | | | | | | | |
| **СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 1. ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ** | | | | | | | | |
| 1.1. | Төрийн цахим үйлчилгээтэй холбоотой салбар дундын зохицуулалт хийх байгууллагатай уулзалт зохион байгуулах; | Улсын төсөв | Зохицуулалтыг сайжруулах хүрээнд хамтран ажиллах байгууллагын тоо | 56 | 54 | 54 | Төрийн үйлчилгээний нэгдсэн системд үйлчилгээ нэвтрүүлэх чиглэлээр 19 байгууллагатай хамтран ажиллаж, уулзалт зохион байгуулж, 4 үйлчилгээг Дэлхийн банкнаас хэрэгжүүлж байгаа “Ухаалаг засаг 2” төслийн хүрээнд цахим хэлбэрт шилжүүлэхээр шийдвэрлэсэн.<br><br>Хамтран ажилласан байгууллагын тоо 19 | 100 |
| | | - | Хууль тогтоомжийн төсөлд санал өгөх тоо | - | - | 1 | Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигээр ахлуулсан Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсэгт ажиллан, санал боловсруулахад оролцсон.<br>Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ын “Шилэн индекс”-ийн тайлангийн 5 бүлэг 87 шалгуур үзүүлэлтийг файл, зурагтай байх эсэх дээр санал боловсруулан 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Цахим | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хөгжил, инновац, харилцаа холбооны яамны холбогдох газарт хүргүүлсэн.<br><br>Нийт 3 санал хүргүүлж, 1 ажлын хэсэгт ажилласан. | |
| 1.2. | Төрийн цахим үйлчилгээг дахин загварчлах үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах; | Улсын төсөв | Үе шат буурсан үйлчилгээний тоо | 1 | 16 | 16 | Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia.mn)-ээр дамжуулан үзүүлж буй үйлчилгээг иргэдэд шуурхай, чирэгдэлгүй хүргэх, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор дахин загварчлах, төрийн үйлчилгээний үе шатыг бууруулах талаар санал, зөвлөмж гаргах ажлыг хийж гүйцэтгэн 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга болон холбогдох албан хаагчдад танилцуулсан.<br>Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia.mn, operator.e-mongolia.mn, аппликейшн)-д 2019-2024 онуудад 1273 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, 74,251,706 үйлчилгээг хүргэсэн тоон мэдээлэлд судалгаа хийж, чанарыг сайжруулах хүрээнд мэдээлэл нийлүүлэгч байгууллагын нэрийг олон төрлөөр бичиж, үйлчилгээг давхардуулсан 21 байгууллагын 113 үйлчилгээ, 1 байгууллагын нэр хуучнаар бичигдсэн, 10 байгууллагын 24 үйлчилгээний нэр давхардсан, үйлчилгээний нэр тодорхой бус бичигдсэн 3 байгууллагын 30 үйлчилгээ, химийн хорт болон аюултай бодистой холбоотой хасагдах 30 үйлчилгээ, спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх зөвшөөрлийн хасагдах 20 үйлчилгээ, системд нэвтрүүлэхээр туршилт хийсэн 3 үйлчилгээг цахим хэлбэрт нэвтэрсэн үйлчилгээний тоонд оруулсан зэрэг алдаа, давхардал байгаа бөгөөд өөрчлөх шаардлагатай нийт 220 үйлчилгээ байна.<br>Цахим хэлбэрт шилжүүлсэн үйлчилгээнээс хүн, хуулийн этгээдийн огт аваагүй үйлчилгээнд | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | судалгаа хийж үзэхэд Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia.mn, operator.e-mongolia.mn)-д 1273 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлснээс нийт 52 байгууллагын 527 үйлчилгээг огт аваагүй байна.<br>Судалгааны үр дүнгээс харахад алдаатай, бүрэн бус утгатай, давхардаж оруулсан зэрэг 119 үйлчилгээг хасаж, 1154 үйлчилгээг судалж үзэхэд 660 төрлийн үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд үзүүлсэн байна. Хүн, хуулийн этгээдэд хэрэгцээ шаардлага багатай 494 үйлчилгээ байгаа тул давхардсан, нэг ижил утга, зориулалттай үйлчилгээнүүдийг нэгтгэх, алдаатай, бүрэн бус өгөгдөлтэй үйлчилгээг хянан засварлах, хууль тогтоомжийн дагуу өөрчлөгдсөн үйлчилгээг залруулж оруулах, тодорхой бус нэршил, үйлчилгээ нь тодорхойгүй үйлчилгээнүүдийг хууль тогтоомжид нийцүүлэн тодорхойлсноор 125 үйлчилгээ болгож үйлчилгээний чанарыг сайжруулах боломжтой байна.<br>Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia.mn)-ээр дамжуулан үзүүлж буй үйлчилгээг иргэдэд шуурхай, чирэгдэлгүй хүргэх, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор үйлчилгээний чанарыг сайжруулах судалгааг боловсруулсан талаар дэлгэрэнгүй болон товч тайланг хянан засварлаж, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 01/376 дугаар албан бичгээр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд хүргүүлсэн.<br>Гадаадын иргэн харьяатын газрын Мэдээлэл технологийн хэлтсийн мэргэжилтэн, Чанар хяналтын газрын дарга болон холбогдох мэргэжилтэн нарын хамтарсан уулзалтыг 02 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулж, гадаад иргэдийг Монгол Улсын хилээр орж ирэхэд олгодог 13 орон бүхий тоог системд нэвтрүүлж болох эсэх, хил дээр олгодог F | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | регистрийг ашиглаж, ХАӨМС-нд нэвтрүүлж ашиглах талаар санал солилцсон. Мөн тус байгууллагаас гадаад иргэдийн боловсрол, эрүүл мэнд, халамжийн асуудлын талаар хүсэлт гаргасны дагуу тухайн чиглэлийн байгууллагуудтай хамтарсан уулзалтыг зохион байгуулахаар шийдвэрлэсэн.<br>Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгийн холбогдох албан хаагчидтай 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдөр "Галын материалын сорилтын дүгнэлт"-ийн лавлагаа тодорхойлолтыг цахим хэлбэрт шилжүүлэх талаар уулзалт зохион байгуулж, тухайн үйлчилгээг Дэлхийн банкнаас хэрэгжүүлж байгаа "Ухаалаг засаг 2" төслийн хүрээнд цахим хэлбэрт шилжүүлэхээр шийдвэрлэсэн.<br>Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, Үндэсний статистикийн хорооны удирдлагатай 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр хамтарсан уулзалт зохион байгуулж, уулзалтын хүрээнд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой танилцуулга бэлтгэн танилцуулж, судалгаа хийх, "Хүн ам, өрхийн мэдээллийн сан" (ХАӨМС)-г төрийн үйлчилгээний нэгдсэн системд нэвтрүүлэх асуудлаар санал солилцсон.<br>Орхон аймгийн Стандарт, хэмжил зүйн газраас MNS ISO/IEC17025:2018 стандартын дагуу 88 нэр төрлийн бүтээгдэхүүнд 543 шинжилгээний хариуг цахим хэлбэрт шилжүүлэх хүсэлт ирүүлснийг Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй Ухаалаг засаг-2 төслийн хүрээнд Стандарт, хэмжил зүйн газрын 12 төрлийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхээр тусгагдсан жагсаалтад багтсан талаар 01/313 дугаар албан бичгээр хариу хүргүүлсэн. | |
| | | - | Мэдээлэл хариуцагч | 2 | 2 | 2 | Тайлант хугацаанд төрийн цахим үйлчилгээг дахин загварчлах үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах ажлын хүрээнд 19 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | байгууллагын тоо | | | | мэдээлэл хариуцагч байгууллагатай уулзалт зохион байгуулсан. | |
| | | - | Төрийн үйлчилгээг боловсронгуй болгох хүрээнд дэд системийг хөгжүүлэх, хэвийн үйл ажиллагааг хангах системийн тоо | 1 | - | 4 | Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдээс хүн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа үйлчилгээ, чиглэлийг тодорхойлох, нэгдсэн мэдээллийн бүртгэлийг бүрдүүлэх зорилгоор 16 яам, 21 аймаг, Засгийн газрын 40 агентлагаас хүн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа төрийн цахим үйлчилгээний талаарх мэдээллийг ирүүлэх албан бичиг хүргүүлснээс Засгийн газрын 34 агентлаг 748, 11 яам 111, 20 аймаг 7441 (давхардсан тоогоор) үйлчилгээг үзүүлж байгааг тоон судалгаагаар тодорхойлсон.<br>Мөн судалгаагаар төрийн байгууллагуудад ашиглаж байгаа мэдээллийн систем, программ хангамжийн талаарх мэдээллийг авах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.<br>Жишээ дурдахад: Оюуны өмчийн газар нь Аж үйлдвэрийн өмчийн удирдлагын IPAS систем, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох систем (PMT2022), Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар нь Шийдвэр гүйцэтгэлийн бүртгэл хяналтын систем, Хөрөнгө оруулалт, худалдааны газрын https://e-invest.mn/ системийг тус тус ашиглаж байна. | 100 |
| **АЛСЫН ХАРАА 2050-ЫН ХҮРЭЭНД 2021-2030 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 5.3.5, МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 4.3.3.6, МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 4.1.2.8** | | | | | | | | |
| **СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ 2: БҮХ НИЙТИЙН ЦАХИМ УР ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЖ, ЦАХИМ ШИЛЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ** | | | | | | | | |
| 2.1. | Цахим шилжилтийг эрчимжүүлэх хүрээнд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд Нээлттэй мэдээллийн системийн талаар мэдээлэл хариуцагч байгууллагуудад | - | Хамрагдсан албан хаагчийн тоо | 2000 | 1500 | 1500 | Засгийн газрын "Шил" ажиллагааны хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-ийн 2.0 хувилбарын сургалтыг төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, сумын Засаг даргын Тамгын газар, аймгийн харьяа газар, хэлтсийн нийт 844 албан хаагчдад | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | зөвлөгөө, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулах; | | | | | | танхим болон цахим хэлбэрээр зохион байгуулсан.<br>"Шилэн индекс"-ийн тайланг хүлээн авч, хянах, үнэлэх, баталгаажуулах, байгууллага бүртгэх, системд хандах эрх нээх зэрэг асуудлаар мэдээлэл хариуцагч байгууллагын нийт 547 албан хаагчдад зөвлөгөө, мэдээллийг 70122626 тусгай дугаарын утас, цахим орчин, албан хаагчийн хувийн (гар утасны дугаар) харилцааны хэрэгслээр, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын пэйж хуудас болон youtube.com платформд байршуулан нийт 24857 хүн, хуулийн этгээдэд зөвлөгөө, мэдээллийг хүргэж ажилласан.<br><br>Нийт 26248. | |
| 2.2. | Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-д шилэн индексийн тайлан илгээх, үнэлэх, баталгаажуулах, хэвлэн нийтлэх чиглэлээр контент бэлтгэх, мэдээлэл хариуцагч байгууллагуудад түгээх ажлыг зохион байгуулах; | 19,900,000 | Хандалтын тоо | - | 3 | - | Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-д шилэн индексийн тайлан илгээх, үнэлэх, баталгаажуулах, хэвлэн нийтлэх, мэдээлэл шинэчлэх чиглэлээр цуврал 3 контент бэлтгэн мэдээлэл хариуцагч байгууллагуудад хүргэх, түгээх ажлыг зохион байгуулж, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын цахим хуудас болон youtube.com платформд байршуулан нийт 24857 хүн, хуулийн этгээдэд мэдээллийг хүргэж ажилласан.<br>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт, Нээлттэй мэдээллийн (shilen.gov.mn) системд "Шилэн индекс"-ийн тайлан илгээх, байршуулах талаар Монголын үндэсний олон нийтийн телевиз, Eagle Телевизийн зочны цагт оролцон мэдээлэл өгсөн. | 100 |
| 2.3. | Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр төрийн цахим үйлчилгээг үзүүлж байгаа албан хаагчдад төрийн цахим үйлчилгээний талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх; | 11,166 000, | Хамрагдсан албан хаагчийн тоо | 85 | 75 | 75 | "Шилэн индекс"-ийн тайланг хүлээн авч, хянах, үнэлэх, баталгаажуулах, байгууллага бүртгэх, системд хандах эрх нээх зэрэг асуудлаар мэдээлэл хариуцагч байгууллагын нийт 65 албан хаагчдад 70122626 тусгай дугаарын утсаар, 482 албан хаагчдад цахим орчин (Shilen all, хувь viber chat), хувь албан хаагчийн харилцааны хэрэгсэл | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | (гар утас) -ээр зөвлөгөө, мэдээллийг өгч ажилласан.<br><br>Нийт зөвлөгөө, мэдээллийн тоо 547. | |
| 2.4. | Төрийн цахим үйлчилгээтэй холбоотой асуудлаар хүн, хуулийн этгээдтэй харилцах эргэх холбооны тоглолцоог бүрдүүлэх; | Улсын төсөв | Төрийн үйлчилгээний нэгдсэн лавлах системийг нэвтрүүлэх талаар судалгаа хийх | - | - | 1 | Төрийн цахим үйлчилгээтэй холбоотой асуудлаар хүн, хуулийн этгээдтэй харилцах эргэх холбооны тогтолцоог бүрдүүлэх ажлын хүрээнд ажиллах албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтын төслийг боловсруулж, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2023 оны А/85 дугаар тушаалаар батлагдсан Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн хөтөлбөрт өөрчлөлт оруулах бүтцийн саналыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд 2024 онд хүргүүлсэн бөгөөд яамнаас бүтэц батлагдаагүй учраас хүлээгдэж байна. | 50 |
| 2.5. | Хүн, хуулийн этгээдээс тусгай дугаараар болон бусад хэлбэрээр ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авах, холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэх, хяналт тавих. | - | Хүсэлт хүлээн авсан тоо | 662 | 831 | 831 | Тайлант хугацаанд 7012-2626 тусгай дугаарт байршил, цагийн хуваарьтай холбоотой 8, гомдол 2, хүсэлт 7, талархал 5, заавар, зөвлөгөө, мэдээлэл 42, Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-тэй холбоотой асуудлаар хандсан 65, бусад асуудлаар хандсан 20, нийт 149 хүн, хуулийн этгээдийн дуудлагыг авч, холбогдох байгууллага, газар, нэгжид асуудлыг уламжлан, зөвлөгөө, мэдээллээр хангаж ажилласан.<br>Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын цахим хуудасны санал, хүсэлтийн цэсэд нийт 77 иргэний ирүүлсэн санал, хүсэлтийг хүлээн авч бүртгэн, холбогдох байгууллага, газар, нэгжид асуудлыг уламжлан хуулийн хугацаанд шийдвэрлэж, тухайн иргэдэд хариуг мэдэгдэж ажилласан.<br>Мөн 70122626 тусгай дугаарын утсыг төрийн цахим үйлчилгээ, нийслэл дэх ХУРДАН цэг, киоск машины байршил, цагийн хуваарь, аймаг дахь ХУРДАН цэг, киоск машины байршил, цагийн хуваарь, үйлчилгээний ажилтантай холбоотой | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | санал гомдол, талархал, цахим ур чадварын сургалт, Нээлттэй мэдээлэл систем shilen.gov.mn-ийн үнэлгээ, цахим ур чадварын сургалт, байгууллагын бичиг хэрэг, системийн талаар гэж 9 хэсэгт ангилан хуваасан нь 1 газарт оногдох дуудлагын тоо буурсан үндэслэл болсон.<br><br>Нийт 226 иргэний санал хүсэлтийг шийдвэрлэсэн. | |
| | | - | Хэрэглэгчийн үнэлгээний хувь | - | 30 | 30 | Тайлант хугацаанд 7012-2626 дугаарт иргэдээс ирүүлсэн үйлчилгээний ажилтантай холбоотой 5 талархал ирсэн.<br>(*Төв шуудан дах ХУРДАН цэгийн ажилтан Гэрэлмаад талархал илэрхийлье. Тэвдэж, сандарч явахад маш их тус болж, төрийн үйлчилгээ ингэж хурдан хүрдэг болсныг зааж үйлчилж өглөө. Удирдлагад нь дамжуулж өгнө үү? ХУРДАН-гийн бүх хүмүүст баярлалаа.*) | 100 |
| | | - | Зөвлөгөө мэдээллийн тоо | 300 | 500 | 500 | Тайлант хугацаанд 7012-2626 тусгай дугаарт заавар, зөвлөгөө, мэдээлэл хүссэн 42, нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-тэй холбоотой асуудлаар заавар, зөвлөгөө авахаар хандсан 65 албан хаагч, цахим орчин (Shilen all, хувь viber chat)-д 482 албан хаагчид хувь албан хаагчийн харилцааны хэрэгсэл (гар утас)-ээр зөвлөгөө, мэдээлэл өгч, нийт 589 хүн, хуулийн этгээдийг зөвлөгөө, мэдээллээр хангаж ажилласан. | 100 |
| **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 4.2.2.1, МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 4.1.2.5** | | | | | | | | |
| **СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 3. ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНД ИННОВАЦ, ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИ (ДИЖИТАЛ)-ИЙГ НЭВТРҮҮЛЖ СИСТЕМИЙН ИНТЕГРАЦИ ХИЙХ** | | | | | | | | |
| 3.1. | Төрийн цахим үйлчилгээний процессын дахин инженерчлэлийг зохион байгуулалтаар хангах; | - | Дахин инженерчлэл хийгдсэн байгууллагын тоо | 1 | 1 | 2 | • Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар 2024 оны дөрөвдүгээр сараас эхлэн “Шинэ сэргэлтийн бодлогын хурдасгуур төв” ТӨҮГ болон “Систем Арт Венчурс” ХХК-тай хамтран “Жижиг, дунд үйлдвэрийн газар”-аас хүн, хуулийн этгээдэд үзүүлж буй төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийсэн ажлын үр дүнд боловсруулсан тайланг | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | танилцуулах уулзалтыг 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулж, Жижиг, дунд үйлдвэрийн газарт процессын дүн шинжилгээг хийсэн тайлан, ирээдүйн загвар буюу To-Be загварын тайланг хүлээлгэн өгсөн. Тус газрын үйл ажиллагааны процессыг оновчилж, хүн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа үйлчилгээ (лавлагаа, тодорхойлолт, нэг болон олон шатлалт үйлчилгээ)-г тодорхойлж Жижиг, дунд, үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох (сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих), жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийг бүртгүүлэх (тодорхойлолт олгох, авах) гэсэн 2 үйлчилгээг Дэлхийн банкнаас хэрэгжүүлж байгаа "Ухаалаг засаг 2" төслийн хүрээнд цахим хэлбэрт шилжүүлэхээр шийдвэрлэсэн.<br>• Процессын дахин инженерчлэл хийхэд тулгамдаж буй асуудал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр "Процессын дахин инженерчлэл" сэдэвт хэлэлцүүлгийг хувийн хэвшлийн 12 байгууллагыг хамруулан зохион байгуулсан.<br>• Seed approach XXK-тай 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдөр, Ай Эм Си Эй ХХК, ЭМ АЙ СИ ЖИ ХХК, Пи Ви Си монголиа ХХК, Би Пи Сольюшн ХХК, Хаан банк, Худалдаа хөгжлийн банк зэрэг 7 байгууллагатай 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрөөс 21-ний өдрүүдэд процессын дахин инженерчлэлийг төрийн байгууллага хэрхэн хийх ямар асуудал дээр анхаарах, манай улсад тус чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын хүний нөөц чадавх, туршлагын талаар мэдээлэл солилцож ажилласан.<br>• Австралийн Прайм Би Пи Эм ХХК-ний суурин төлөөлөгч Infosolution ХХК-тай 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдөр, процессын дахин | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | инженерчлэл хийхэд ашиглагддаг программ хангамж, туршлага, үйл ажиллагааны онцлог, давуу талын асуудлаар ярилцан, хэрхэн ашиглах талаар мэдээлэл солилцох уулзалтыг зохион байгуулсан.<br>• Стандарт, хэмжил зүйн газар, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн Ажлын хэсэг байгуулах тухай А/27, А/06 дугаар хамтарсан тушаалаар Засгийн газрын тохируулагч агентлаг - Стандарт, хэмжил зүйн газрын стратегийн зорилго, зорилтын хэрэгжилтийг хангах, үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах, дахин инженерчлэл хийх, хүн, хуулийн этгээдэд хүргэж байгаа үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, төрийн байгууллага өөрт байгаа, эсхүл нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах, солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байх зарчмыг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийн хурлыг нийт 7 удаа зохион байгуулж, процессын дахин инженерчлэл хийх талаар мэдээлэл өгч, хэрэгжүүлэх ажлын талаар харилцан санал солилцсон. Стандарт хэмжил зүйн газар, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, “АЙ ЭМ ЭС ЭЙ” ХХК, “Систем Арт Венчурс” ХХК хамтран 5 үе шат бүхий хамтарсан төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, байгууллагын процессын дүн шинжилгээг хийх, ирээдүйн загвар буюу To-Be загвар боловсруулах ажлыг хийж гүйцэтгэхээр ажиллаж байна. Ажлын хэсгээс хэрэгжүүлэх ажлын хүрээнд Стандарт, хэмжил зүйн газрын хэлтэс, нэгжүүдтэй 7 хоног бүрийн мягмар, пүрэв гарагт “Процессын дахин инженерчлэл”-ийн үндсэн процессын зураглал хийх ажлыг | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хийж гүйцэтгэж байгаа бөгөөд IMSA ХХК, Систем арт венчурс ХХК-тай хамтран 2025 оны 05 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд Дархан-Уул, Сэлэнгэ аймагт ажиллан "Процессын дахин инженерчлэл"-ийн үндсэн процессын зураглал хийх ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>• Австрали Улсын "Прайм бизнес процессын менежмент" компанийн төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, тус компанийн процессын дахин инженерчлэлийн чиглэлээр 20 гаруй жил ажилласан туршлага, Австрали, АНУ, Европын орнуудад үйл ажиллагаа явуулсан, өнгөрсөн хугацаанд дэлхийн төрийн болон хувийн хэвшлийн 400 гаруй томоохон байгууллагад процессын дахин инженерчлэлийг амжилттай хэрэгжүүлсэн туршлага, тухайн үйл ажиллагааг гүйцэтгэхдээ өөрсдийн хөгжүүлсэн тусгай цахим системийг ашиглан семуляци хийж процессын дахин инженерчлэлээс гарсан үр дүнг нэвтрүүлэх, тасралтгүй хөгжүүлэлт, сайжруулалт хийдэг олон жилийн туршлагатай танилцан, мэргэжил, арга зүйн зөвлөгөө авснаас гадна цаашид хамтран ажиллах боломжтой талаар санал илэрхийлсэн.<br>• Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Засгийн газрын 2023 оны 100 дугаар тогтоолын хүрээнд Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, хүн, хуулийн этгээдэд тэгш, хүртээмжтэй хүргэх, төрийн цахим үйлчилгээг боловсронгуй болгох, дахин загварчлах, хүн төвтэй болгох, бүтээмжийг нэмэгдүүлэх, процессын дахин инженерчлэлийн талаар хийж хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны тайлан, үр дүнгийн мэдээллийг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 01/295 дугаар албан бичгээр Монгол Улсын Их Хурлын гишүүн Ч.Анарт хүргүүлсэн. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | • Баян-Өлгий, Өмнөговь аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн хүсэлтийн хүрээнд тус хоёр аймгийн албан хаагчдад Процессын дахин инженерчлэлийн талаарх сургалтыг 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулж, сургалтад нийт 140 албан хаагч хамрагдсан. | |
| | | - | Стандартын хэрэгжилтийн хувь | - | 60 | 40 | Стандарт, хэмжил зүйн газрын үйл ажиллагаанд процессын дахин загварчлал хийх ажлын хүрээнд процессын өнөөгийн нөхцөл байдлын тодорхойлсон шинжилгээний ажлын тайланг хийж гүйцэтгэсэн. | 60 |
| 3.2. | Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-д мэдээлэл хариуцагч байгууллагын шилэн индексийн тайлан илгээх, хүлээн авах, үнэлэх, баталгаажуулах, хэвлэн нийтлэх байдалд хяналт тавих, хяналтын тогтолцоог сайжруулах ажлыг зохион байгуулах; | - | Хянан баталгаажуулсан байгууллагын тоо | 575 | 912 | 913 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан нийтийн мэдээлэл хариуцагч байгууллагуудын жагсаалтыг аймаг, нийслэл, дүүрэг тус бүрээр ангилан гаргаж, Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн 5600 гаруй мэдээлэл хариуцагч байгууллагын жагсаалттай тулгах ажлыг хийж гүйцэтгэн, Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-д бүртгүүлэх байгууллагын жагсаалтыг шинэчлэн боловсруулсан.<br>Засгийн газрын агентлаг, аймгийн Засаг даргын Тамгын газар, нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон харьяа байгууллагын нээлттэй мэдээллийн "Shilen.gov.mn" системд 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар "Шилэн индекс"-ийн тайлан илгээсэн 1126 байгууллагын тайланг баталгаажуулан, олон нийтийн портал системд хэвлэн нийтэлсэн.<br>"Шилэн индекс"-ийн тайланг нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-ээр илгээсэн төрийн захиргааны төв байгууллага 92.61% (Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон 11 яам), төрийн захиргааны байгууллага 79.61% (23 агентлаг), Нийслэлийн Засаг даргын Тамгын газар 60.6% (5 Засаг Даргын тамгын газар), нутгийн захиргааны байгууллага 78,84% (15 аймаг)-тай үнэлэгдсэн байна. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Авлигатай тэмцэх газраас 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр ирүүлсэн Мэдээлэл хүсэх тухай албан бичгийн хүрээнд Шилэн индексийн үнэлгээ болон бусад холбогдох мэдээллийг нэгтгэн Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 04/203 дугаар албан бичгээр хариуг хүргүүлсэн.<br>Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.1 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайд Улсын Их хурлын нэгдсэн хуралдаанд “Шил ажиллагаа”-ны хэрэгжилтийг танилцуулахад шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах ажлын хэсэгт ажиллан холбогдох тайлан, мэдээ, мэдээллийг цаг хугацаанд гарган өгч ажилласан.<br>Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдаас 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр ирүүлсэн Ажил эрчимжүүлэх тухай 01/983 дугаар албан бичгээр Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-д байршуулсан мэдээллийг үнэлэх, хянан баталгаажуулах, хэвлэн нийтлэх ажлыг хариуцан гүйцэтгэх албан хаагчдыг сургах, дадлагажуулах, чадавхжуулах ажлыг зохион байгуулж ажиллах чиглэлийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын тайланг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд хүргүүлсэн.<br>Нээлттэй мэдээллийн (shilen.gov.mn) системийн 3.0 хувилбарыг нэвтрүүлэх үйлчилгээний ажлын даалгаварт тусгах саналыг боловсруулан Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны холбогдох мэргэжилтэнд Төрийн цахим шуудангаар 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр илгээсэн. | |
| | | - | Зөвлөмжийн тоо | 26 | 25 | 26 | • Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-д байгууллагын бүртгэл үүсгэх, Шилэн индексийн тайланг хуульд заасан хугацаанд илгээх чиглэлээр Засгийн газрын 40 агентлаг, 21 аймгийн Засаг даргын Тамгын газар, | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Алтанбулаг, Цагааннуур, Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба, нийт 65 байгууллагад албан бичиг хүргүүлсэн.<br>• Монгол Улсын Их Хурлын 2024 оны 46 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 2.5 дугаар зорилтын 2.5.2.2 хэсэгт "Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтэд хоёр жил тутам үнэлгээ хийж, олон нийтэд мэдээлэх" арга хэмжээ тусгагдсан. Уг ажлын хүрээнд үнэлгээ хийх талаар Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр ирүүлсэн 01/133 дугаартай албан бичгийн хүрээнд тус газрын холбогдох мэргэжилтнүүдтэй уулзалт зохион байгуулж, үнэлгээнд хамруулах арга хэмжээний жагсаалтыг гаргаж хүргүүлэн, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн зарим заалтыг хэрэгжүүлэх чиглэлээр хийсэн ажил, мэдээ, мэдээллийг боловсруулан нэгтгэж, газрын 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 01/563 дугаар албан бичгээр хариуг хүргүүлсэн.<br>• Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Авлигатай тэмцэх тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын 2022 оны Журам батлах тухай (Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам) 201 дүгээр тогтоол, Засгийн газрын 2022 оны Журам батлах тухай (Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам) 352 дугаар тогтоол, Засгийн газрын 2023 оны "2023-2024 оныг авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай" 49 дүгээр тогтоол, 2023 оны Монгол | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Улсын Ерөнхий сайдын “Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 01 дүгээр албан даалгавар, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн Чиглэл хүргүүлэх тухай 01/1147, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн Шил ажиллагааны хэрэгжилтийг хангах тухай 01/924, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн Ажил эрчимжүүлэх тухай 01/983 дугаар албан бичиг, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн Авлигатай тэмцэх “5Ш” ажиллагааны хүрээнд “Шил ажиллагаа”-ны хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар ханган, шаардлагатай мэдээ, мэдээллийг нэгтгэж, шилэн индексийн үнэлгээг зарлах үүрэг бүхий Штабыг шинэчлэн байгуулах тухай А/46 дугаар тушаал зэрэг холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийж, “Шилэн индекс”-ийн тайланг ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журмын хүрээнд эрх бүхий албан хаагчид үнэлсэн, хянан баталгаажуулсан байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зөвлөмж хүргүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор хийх хяналт, шалгалтын удирдамжийг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргаар 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдөр батлуулсан. Хяналт, шалгалтыг 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн 03 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд 22 байгууллагад хийж гүйцэтгэсэн.<br>• Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/46 дугаар тушаалаар байгуулагдсан | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Авлигатай тэмцэх “5ш” ажиллагааны хүрээнд “Шил ажиллагаа”-ны хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, шаардлагатай мэдээ, мэдээллийг нэгтгэж, шилэн индексийн үнэлгээг зарлах үүрэг бүхий штабын үйл ажиллагааны 2025 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний төсөлд өгөх санал, Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-д “Шилэн индекс”-ийн тайлан илгээх, тайланг үнэлж, хянан баталгаажуулах хугацааны төслийг боловсруулсан. | |
| 3.3. | Төрийн цахим үйлчилгээний ХУРДАН цэгийн хэвийн үйл ажиллагаа, үйлчилгээний ажилтны үйлчилгээ үзүүлэхэд мөрдөгдөх хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт бусад шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, зөвлөмж хүргүүлэх; | - | Зөвлөмжийн тоо | 26 | 5 | 25 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар тогтоол, Засгийн газрын 2023 оны 100 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас хүн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны журам”, Засгийн газрын 2023 оны 224 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журам”, MNS 6984:2022 “Төрийн үйлчилгээг операторын горимоор үзүүлэхэд тавих шаардлага”, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны “Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын брэндбүүк батлах тухай” А/13 дугаар тушаал, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын 2023 оны А/28 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн цахим үйлчилгээний “ХУРДАН” цэгийн үйл ажиллагааны түр журам”-ын хэрэгжилтэд хяналт, шалгалт хийж, үйл ажиллагааг сайжруулах, цаашид авах арга хэмжээний талаар зөвлөмж хүргүүлэх хяналт, шалгалтын удирдамжийг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргаар батлуулан төрийн цахим үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд хүргэж байгаа Хан-Уул, Чингэлтэй, Баянзүрх, Багануур, Багахангай, Налайх дүүргийн нийт 36 хороонд | 40 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байрлах ХУРДАН цэг, сумдад байрлах 215 ХУРДАН цэгийн үйл ажиллагаанд 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдрөөс 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хяналт, шалгалтыг хийж гүйцэтгэсэн.<br>Хяналт, шалгалтыг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын 2023 оны А/28 дугаар тушаалаар баталсан "Төрийн цахим үйлчилгээний ХУРДАН цэгийн үйл ажиллагааны түр журам"-ын хавсралтаар батлагдсан "ХУРДАН" цэгийн ажлын байранд тавигдах шаардлага, үнэлгээний хуудас, үйлчилгээний ажилтны харилцаа, хандлага, үйлчилгээ үзүүлэх ур чадвар, харагдах байдал, эмх цэгцийг хэмжих үнэлгээний хуудасны цэгийн тохижилт, цэгийн тоног, төхөөрөмжийн иж бүрэн байдал, цэгийн тоног, төхөөрөмж хэвийн ажиллаж байгаа эсэх, үйлчилгээний ажилтны мэдлэг, ур чадвар, мэдээллийн аюулгүй байдал зэрэг шалгуур үзүүлэлтийн дагуу хийж гүйцэтгэсэн.<br>Хяналт, шалгалтын зөвлөмжийг Чанар хяналтын газрын 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 07, 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 11 дүгээр дотоод албан бичгээр Үйлчилгээний нэгдсэн төвийн зохицуулалтын газарт хүргүүлэн, тус газраас ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна.<br><br>Нийт 36 хороо, 215 суманд байрлах ХУРДАН цэгийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж тайланг гаргаж, 2 зөвлөмж хүргүүлсэн. | |
| 3.4. | Төрийн цахим үйлчилгээний ХУРДАН цэгийн хэвийн үйл ажиллагаанд хяналтын камераар хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээг холбогдох | Улсын төсөв | Хяналтын тоо | 14 | 15 | 15 | Төрийн цахим үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд хүргэж байгаа нийслэл дэх 11 цэгийн үйл ажиллагаанд хяналтын камераар хяналт тавих хуваарийг Чанар хяналтын газрын даргаар батлуулан, албан хаагчдад хяналт, шалгалт хийх талаар үүрэг чиглэл өгч, хуваарийн дагуу 16 удаа хяналт тавьж ажилласан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нэгжтэй хамтран зохион байгуулах; | | | | | | Мэдээллийн аюулгүй байдлын аудитаас өгөгдсөн зөвлөмжийн дагуу ХУРДАН цэгүүдийн камерын хяналттай холбоотой нэгдсэн шийдэл, шийдвэр гаргах, камерын бичлэгийг хуульд нийцүүлсэн байдлаар хадгалдаг байх ажлыг хэрэгжүүлэх үүднээс Чанар хяналтын газарт камер хяналтыг байршуулах ажлын хүрээнд ашиглагдах 80-85, 60 инчийн дэлгэц зэрэг тоног төхөөрөмжийн жагсаалтыг гарган холбогдох газарт хүргүүлсэн. | |
| 3.5. | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (киоск)-д нэвтрүүлсэн төрийн цахим үйлчилгээний хэвийн үйл ажиллагаанд хяналт тавих; | Улсын төсөв | Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (*портал, аппликейшн, оператор, киоск*)-д хяналт хийсэн тоо | 310 | 342 | 343 | Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 03/1105 дугаар "Чиглэл хүргүүлэх тухай" албан бичгийн дагуу тус газрын даргын 2024 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн А/68 дугаар ажлын хэсэг байгуулагдаж, киоск машины хэвийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан.<br><br>Нийслэл, орон нутгийн хэмжээнд нийт 505 киоск машин байршуулахаас нийслэлд 127, орон нутагт 84, (тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан 22 киоск машин), хилийн боомтод 4 нийт 237 киоск машиныг тус тус байршуулан, киоск машинд 20 байгууллагын 103 үйлчилгээг нэвтрүүлэх хөгжүүлэлт хийснээс 91 үйлчилгээ идэвхтэй, засвар үйлчилгээ хийгдэж идэвхгүй 11, хууль журмын дагуу хасах 2 үйлчилгээ байна.<br>Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор төрийн байгууллагуудад ашиглагдаж байгаа киоск машин болон түүнтэй адилтгах төхөөрөмжийн судалгаа авах чиглэлээр Засгийн газрын 37 агентлаг, 21 аймгийн Засаг дарга, Нийслэлийн Засаг дарга, 9 дүүргийн Засаг дарга нарт албан бичиг хүргүүлсэн.<br>Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/19 дүгээр тушаалаар киоск машины байршлыг тогтоох, өөрчлөх, түүний хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах бүхий л арга хэмжээг авах ажлыг зохион байгуулах, хяналт тавих чиг үүрэг | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийн хурлыг 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулж, аймгуудад байрлах киоск машинд нэвтрүүлэх үйлчилгээг тухайн аймагт хэрэгцээтэй байдлаар оруулах, киоск машины хэвийн үйл ажиллагаанд анхаарах, киоск машинаар хүн, хуулийн этгээдэд хүргэж байгаа үйлчилгээний тоог гаргах зэрэг асуудлыг хэлэлцсэн.<br>Чанар, хяналтын газар, Систем нэгтгэл, сургалт хөгжлийн газрын Систем нэгтгэлийн хэлтэс, Гэрэгэ киоск ХХК, Капитрон банкны холбогдох албан хаагчдын хамтарсан уулзалтыг 2025 оны 05 дугаар 15-ны өдөр зохион байгуулж, Капитрон банкны киоск машинд Гэрэгэ киоск ХХК-ийн хөгжүүлэлт хийсэн төрийн үйлчилгээг нэвтрүүлэх асуудлаар санал солилцож, мэдээллийн аюулгүй байдлын аудит хийлгэж, дүгнэлт гарсны дараа тухайн үйлчилгээг нэвтрүүлэхээр шийдвэрлэсэн.<br>Боомтын сэргэлтийн үндэсний хорооны ажлын албанаас ирүүлсэн 02/630 дугаар албан бичгийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>Өмнөговь аймгийн Шивээ хүрэн боомтод 2025 оны 03 дугаар сард, Дорноговь аймгийн Ханги боомтод 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр ХУРДАН киоск машиныг суурилуулан холболт хийж, хэвийн ажиллагааг хангасан.<br>Дорнод аймгийн Хавирга боомтод байрлуулсан Төрийн үйлчилгээний ХУРДАН киоск машинд боомтын зүгээс гэр интернэтийн төхөөрөмж авч суурилуулан холболтыг хийж, хэвийн ажиллагааг хангасан.<br>Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Дорнод аймгийн Баянхошуу, Дорноговь аймгийн Замын-Үүд, Хөвсгөл аймгийн Ханх зэрэг боомтуудад Төрийн үйлчилгээний ХУРДАН киоск машиныг Гэрэгэ киоск ХХК-иар суурилуулж хэвийн ажиллагааг хангаж ажиллахаар болсон. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Баян-Өлгий аймгийн Цагааннуур боомтод Баян-Өлгий аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсээс Төрийн үйлчилгээний ХУРДАН киоск машин суурилуулан холболт хийж, хэвийн ажиллагааг хангасан. Сүхбаатар аймгийн Бичигт боомтод суурилуулсан ХУРДАН киоск машины холболтыг хийж хэвийн үйл ажиллагааг хангах ажлыг Гэрэгэ киоск ХХК хариуцан хийж гүйцэтгэсэн.<br>Өмнөговь аймгийн Гашуун сухайт боомтын гарах гарцын талбайд “Гэрэгэ киоск” ХХК нь 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр ХУРДАН киоск машин суурилуулан холболт хийж хэвийн ажиллагааг хангасан.<br>Төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, Киоск машины үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийн хүрээнд 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр “Үндэсний дата төв” Улсын төсөвт үйлдвэрийн газар, “Гэрэгэ киоск” ХХК, “И-Монгол академи” Улсын төсөвт үйлдвэрийн газартай хамтарсан уулзалт зохион байгуулсан. Уулзалтаар киоск машинд үйлчилгээний нэршил давхардсан, үг, үсгийн алдаатай, мэдээллийн зөрүүтэй, төрийн байгууллагын нэр хуучнаар тусгагдсан зэрэг зөрчил, алдаа, доголдол байгааг танилцуулж, алдааг засварлаж, киоск машины хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах талаар холбогдох байгууллагуудад үүрэг чиглэл өгч ажилласан.<br>Төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, киоск машины үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийн хүрээнд “Үндэсний дата төв” Улсын төсөвт үйлдвэрийн газраас зарласан тендерт шалгарсан “Гэрэгэ киоск” ХХК-ийн нийлүүлж байгаа киоск машинд нэвтэрсэн 103 үйлчилгээнд тулгалт хийх, нягтлах ажлыг зохион байгуулж ажилласан. Хийсэн хяналт шалгалтын хүрээнд гаргасан үл тохиролыг Үндэсний дата төв Улсын төсөвт үйлдвэрийн газарт шилжүүлэн өгч, | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | киоск машины хэвийн үйл ажиллагааг хангах талаар үүрэг чиглэл өгсөн.<br>Төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор нийслэлийн Засаг даргын тамгын газар, 9 дүүрэг, 21 аймаг, 37 агентлаг, нийт 68 байгууллагад киоск төхөөрөмж ашиглалтын судалгаа авах албан бичиг явуулж, 52 байгууллага судалгаа ирүүлсэн. Үүнээс: Киоск төхөөрөмж ашигладаггүй 22 байгууллага, киоск төхөөрөмж ашигладаг 30 байгууллагын нийт 279 киоскийн судалгааг нэгтгэж ажилласан. | |
| 3.6. | Газрын үйл ажиллагаа, хүн, хуулийн этгээдэд төрийн цахим үйлчилгээг операторын горимоор хүргэх "ХУРДАН" цэгт мэдээллийн аюулгүй байдлын аудитыг эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн хуулийн этгээдээр хийлгэх, зөвлөн туслах үйлчилгээ авах; | 18,500,000 | Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийлгэсэн тоо | - | 1 | | Тус газрын үйл ажиллагаа, хүн, хуулийн этгээдэд төрийн цахим үйлчилгээг операторын горимоор хүргэх "ХУРДАН" цэгт мэдээллийн аюулгүй байдлын аудит, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн хуулийн этгээдээр хийлгэж гарсан дүгнэлт, зөвлөмж, шаардлагын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын 2024 оны А/98 дугаар тушаалаар байгуулсан.<br>Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.6, 17.1.7 дахь заалт, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны А/74 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх этгээдийг бүртгэх, аудит хийх журам", Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Тагнуулын ерөнхий газрын даргын хамтарсан 2024 оны А/30, А/148 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх журам, аргачлал"**-ыг үндэслэн м**эдээллийн аюулгүй байдлын аудитыг "Проактив солюшнс" ХХК-иар гүйцэтгүүлж тайланг хүлээн авч, зөвлөмжийн холбогдох үл нийцлийг засч сайжруулж, мэдээллийн аюулгүй байдлын аудитын баталгаажуулалтын үр дүн, дүгнэлт, зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх төлөвлөгөөг | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | боловсруулан, хугацааг тодорхойлон холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.<br>Мэдээллийн аюулгүй байдлын аудитын талаар сургалтыг 2024 оны 01 дүгээр сарын 17, 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулж, сургалтад газрын албан хаагчид болон аймаг дахь мэдээлэл технологийн ажилтнууд нийт 83 албан хаагч хамрагдсан.нийт 83 албан хаагч хамрагдсан. | |
| 3.7. | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-ийн хөгжүүлэлтийн явцад хяналт тавих, ХУРДАН цэгийн техник тоног төхөөрөмж, программ хангамж, сүлжээний хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдалд хяналт, шинжилгээ үнэлгээ хийж зөвлөмж хүргүүлэх. | 19,305,000 | Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ | - | 1 | | Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалтын дагуу кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийлгэх гэрээний төслийг боловсруулан бэлэн болгосон гэрээ байгуулж гүйцэтгэх этгээдийг сонгон шалгаруулсан бөгөөд санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх асуудал хүлээгдэж байна. | 50 |
| **СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ: 4 БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН, БҮТЭЭМЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ** | | | | | | | | |
| 4.1 | Салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хууль, тогтоолын төсөлд санал өгөх; | Улсын төсөв | Саналын тоо | 2 | 1 | 1 | Цахим мөрийтэй тоглоом, бооцоот тоглоом, төлбөрт тааврын үйл ажиллагаа эрхлэхийг бүхэлд нь хориглох Зөвшөөрлийн тухай хуулийн ажлын хэсэгт ажиллан санал боловсруулахад оролцсон.<br>Нээлттэй мэдээллийн (shilen.gov.mn) системийн 3.0 хувилбарыг нэвтрүүлэх үйлчилгээний ажлын даалгаварт тусгах санал, Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам"-ын Шилэн индексийн тайланг үнэлэх шалгуур үзүүлэлтийг өөрчлөх санал, "Шилэн индекс"-ийн тайлангийн 5 бүлэг 87 шалгуур үзүүлэлтийг файл, зурагтай байх эсэх дээр санал боловсруулсан. | 80 |
| 4.2 | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 100 дугаар тогтоолд нэмэлт өөрчлөлтийн оруулах | - | Саналын тоо | - | - | 1 | Засгийн газрын 2023 оны Журам, жагсаалт, загвар батлах тухай 100 дугаар тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хүрээнд яам, Засгийн | 50 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | санал боловсруулах, хүргүүлэх; | | | | | | газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг болон холбогдох газруудаас санал авч нэгтгэсэн. Боловсролын яам, Эдийн засаг хөгжлийн яамнаас нэмэлт өөрчлөлт оруулахаар ирүүлсэн саналд тусгагдсан үйлчилгээг тодруулах ажил хийгдэж байна. | |
| 4.3 | Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн баталж, биелэлтийг хангах. | - | Журмын тоо | - | - | 4 | Холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд “Хяналт шалгалтын журам”, “Бусдаар ажил үйлчилгээ гүйцэтгүүлэх журам”, Үндсэн болон дэмжих системийн гэмтэл, саатлын үед мэдээлэл солилцох, засварлах, хариу арга хэмжээ авах, тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангах, гэмтэл, саатлаас урьдчилан сэргийлэхтэй холбоотой харилцааг зохицуулах “Үндсэн болон дэмжих системийн гэмтэл, саатлын журам”-ын төслийг боловсруулан, газар, хэлтсийн дарга, “Үндэсний дата төв” Улсын төсөвт үйлдвэрийн газар, “И-Монгол академи” Улсын төсөвт үйлдвэрийн газраас холбогдох санал, процессын зураглалыг хүлээн авч, нийт 3 журмын төслийг боловсруулсан.<br>Газрын даргын 2023 оны А/28 дугаар тушаалаар баталсан Төрийн цахим үйлчилгээний “ХУРДАН” цэгийн үйл ажиллагааны түр журмын төслийг шинэчлэн боловсруулсан.<br>Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын 2023 оны А/28 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн цахим үйлчилгээний ХУРДАН цэгийн үйл ажиллагааны түр журам”- ын ажлын байранд тавигдах тохижилт, тоног төхөөрөмж, нэмэлт хэрэгсэл, үйлчилгээний ажилтны хувцасны стандартад тавигдах 4 бүлгийн 49 шаардлага, цэгийн эмх цэгц, хэвийн үйл ажиллагааг үнэлэх үйлчилгээний цэгийн үзэмж, тохижилт, үйлчилгээний салбарын цэвэрлэгээ, мэдээллийн самбар зэрэг 3 бүлгийн 10 үзүүлэлт, үйлчилгээний ажилтны харилцаа, хандлага, үйлчилгээ үзүүлэх ур чадвар, харагдах байдал, эмх цэгцийг үнэлэх харилцах ур чадвар, | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хандлага үйлчилгээ үзүүлэх ур чадвар, харагдах байдал, эмх цэгцийг үнэлэх 4 бүлгийн 11 үзүүлэлт, нийт 70 шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулж, газар, хэлтсийн дарга нараас санал авч, тушаалын төслийг боловсруулж бэлэн болгосон.<br><br>Нийт 5 журмын төсөл боловсруулсан. | |
| 4.4. | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-д дэд админ, операторын админ, операторын эрх нээх, цуцлах, хяналт тавих | - | Нээх, цуцлах эрхийн тоо | 211/57 | 25 | 25 | Төрийн цахим үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд хурдан шуурхай, тэгш хүртээмжтэй хүргэх үйл ажиллагаанд Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-ийг ашигладаг бөгөөд тус системийн хэвийн үйл ажиллагаа, хөгжүүлэлт, бүртгэлийг хариуцан ажиллах ажлын хүрээнд бүх аймаг, сумдад операторын эрхээр үйлчилгээ үзүүлж байгаа албан хаагчдын судалгааг авч нэгтгэх, хэрэглэгчийн нэгдсэн бүртгэл үүсгэх ажлыг Систем нэгтгэл, сургалт хөгжлийн хэлтэстэй хамтран хийж гүйцэтгэсэн.<br>Нийт 21 аймгаас 377 операторын эрхээр үйлчилгээ үзүүлж байгаа албан хаагчдын жагсаалтыг авч, систем дээрх 611 эрхтэй нэр, регистрийн дугаар, мэйл хаяг, албан тушаал зэргээр тулгалт хийж, 217 операторын эрхийг цуцалсан ба операторын мэйл хаяг солих шаардлагатай 30, системд бүртгэлгүй 58 операторын эрх байгааг гарган холбогдох нэгжид хүргүүлэх ажлыг хийж гүйцэтгэж байна.<br><br>Нийт: 217 эрхийг цуцалж, зөрчлийг арилгуулсан. | 100 |
| 4.5. | Төрийн цахим үйлчилгээг өргөжүүлж, хүртээмжийг сайжруулснаар хэмнэгдэж болох ажлын байр, зардлын судалгаа боловсруулах | - | Судалгааны тоо | - | - | 1 | Төрийн цахим үйлчилгээг өргөжүүлэх хүртээмжийг сайжруулснаар хэмнэгдэж болох ажлын байр, зардлын судалгааг холбогдох байгууллагуудтай хамтран хийх шаардлагатай бөгөөд тус судалгааг “Төрийн цахим шилжилтийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэх, төрийн албан хаагчдын цахим ур чадвар, бэлэн байдал, цахим шилжилтэд оролцогчдын сэтгэл ханамжийн түвшнийг тодорхойлох судалгаа хийх” хамтарсан | 50 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ажлын хэсгийг Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 47 дугаар тушаалаар байгуулсан.<br>Тус ажлын хэсгээс төрийн үйлчилгээ цахим хэлбэрт шилжсэнээр ажлын байрны хэмнэлт гарах, зардлыг бууруулах чиглэлээр Үндэсний статистикийн хороотой 8, Төрийн албаны зөвлөлтэй 5, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Үндэсний статистикийн хороо, Төрийн албаны зөвлөл, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, "И-Монгол академи" УТҮГ-тай нэгдсэн уулзалтыг тус бүр 3 удаа зохион байгуулж, судалгааны асуумжийн төслийг боловсруулаад байна.<br>Төрийн албаны зөвлөлд Төрийн үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд хүргэж байгаа албан хаагчийн сэтгэл ханамжийн судалгаа болон цахим засаглал, цахим шилжилт эрчимжиж төрийн үйлчилгээ цахим хэлбэрт шилжсэнээр төрийн албан хаагчийн орон тоог бууруулах судалгааны ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй, нотолгоонд суурилсан мэргэжил, арга зүйн дэмжлэг авч хамтран ажиллах саналыг газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01/04 дүгээр албан бичгээр хүргүүлсэн. | |
| 4.6. | Төрийн байгууллагаас болон хүн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа үйлчилгээний тоон үзүүлэлтийн талаарх судалгааг дахин боловсруулах | - | Судалгааны тоо | - | - | 1 | Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдээс хүн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа үйлчилгээ, чиглэлийг тодорхойлох, нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх, судалгаа боловсруулах зорилгоор 16 яам, 21 аймаг, Монгол Улсын Засгийн газрын 40 агентлагаас хүн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа төрийн цахим үйлчилгээний талаарх мэдээллийг ирүүлэх албан бичиг хүргүүлснээс Засгийн газрын 34 агентлаг 742, 11 яам, 20 аймаг 7441 (давхардсан тоогоор) үйлчилгээг үзүүлж байгааг тоон судалгаагаар тодорхойлсон. | 60<br>0 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Судалгаанд хамрагдсан 20 аймаг нь давхардсан тоогоор нийт 7,441 үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа бөгөөд 4,865 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлснээс, 3,261 үйлчилгээг Мэдээлэл хариуцагчийн системээр, 508 үйлчилгээг Төрийн үйлчилгээний нэгдсэн системд нэвтрүүлж, 2,576 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлээгүй байна.<br>Судалгаанд хамрагдсан 11 яам 111, 34 агентлаг нь нийт 853 үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд үзүүлдэг бөгөөд 626 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлснээс, 397 үйлчилгээг өөрийн хөгжүүлсэн системд, 229 үйлчилгээг төрийн үйлчилгээний нэгдсэн системд нэвтрүүлж, 227 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлээгүй байна.<br>Үйлчилгээний тоон судалгааг дахин нягталж боловсруулахаар нийт мэдээлэл хариуцагч байгууллагуудад Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газраас "Дэлгэрэнгүй мэдээлэл ирүүлэх тухай" албан бичгийг хүргүүлсэн.<br>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн $32^1$ дүгээр зүйлийн $32^1$.1.5, $32^1$.1.7, $32^1$.7 дахь заалт, Засгийн газрын 2023 оны "Журам, жагсаалт, загвар батлах тухай" 100 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас хүн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны журам"-ын хүрээнд төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүднээс Засгийн газрын агентлаг, Нийслэлийн нутгийн захиргааны болон нийслэлийн өмчит төсөвт байгууллагууд, 21 аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа бүх төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдээс хүн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа үйлчилгээний талаарх | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | судалгааг авах ажлыг зохион байгуулж ажилласан. Тус ажлын хүрээнд:<br>• Нийслэлийн нутгийн захиргааны болон нийслэлийн өмчит төсөвт байгууллагуудад 04 дүгээр сарын 28-ны өдрийн 01/311, 01/312 дугаар албан бичиг;<br>• 21 аймгийн Засаг даргын тамгын газарт 05 дугаар сарын 16-ны өдрийн 01/352-01/372 дугаар албан бичгийг тус тус хүргүүлсэн.<br>Мөн шинээр байгуулагдсан болон судалгаа ирүүлээгүй агентлагуудаас судалгааг авах ажлыг зохион байгуулж, 05 дугаар сарын 09-ний өдрийн 01/350 дугаар албан бичгийг Ургамал хамгааллын газар, Төмөр замын газар, Үндэсний геологийн алба, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Соёл, урлагийн газарт хүргүүлсэн. | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| 1. | Байгууллагаас болон бусад газраас зохион байгуулах сургалтад хамрагдана. | Хамрагдсан сургалтын тоо | 4 | 4 | • Мэдээллийн аюулгүй байдлын аудитын талаар зохион байгуулсан сургалт;<br>• АЙ ЭМ ЭС ЭЙ ХХК-аас зохион байгуулж буй чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015, Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO 27001:2022 стандартуудыг нэвтрүүлэх сургалтад хамрагдсан.<br>• Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Эрүүл мэндийн яам, Нэгдсэн үндэстний байгууллагын хүүхдийн сангаас хамтран 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс 11-ний өдрүүдэд зохион байгуулсан "Цахим эрүүл мэнд" салбар дундын хуралд оролцсон. | 01-12 | 100 |

*Төлөвлөгөөг үнэлсэн:*
Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дарга

**_Төсвийн шууд захирагч_**

*/П.Батбаатар/*

*2025.06.03*

*Тайлагнасан:*
Чанар хяналтын газрын дарга

**_Нэгжийн дарга_**

*/И.Хайратбек/*

*2025.06.03*